

**ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН ОЮУТ БАГТ ШИНЭЭР БАЙГУУЛАГДАХ ӨРХИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАГИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УРИЛГА**

Сонгон шалгаруулалтад оролцогч баг нь “Ерөнхий шаардлага” болон “Тусгай шаардлага” гэсэн хоёр төрлийн шаардлагыг хангасан байна.

Нэг. Тавигдах ерөнхий шаардлага

1. Сонгон шалгаруулалтад оролцох баг нь Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм батлах тухай” А/320 дугаар тушаалын дагуу хязгаарлагдмал хариуцлагатай хэлбэрээс бусад хэлбэрээр зохион байгуулагдсан нөхөрлөл байх,
2. Нөхөрлөлийн гишүүдийн хурлын тэмдэглэл эх хувиар байх,
3. Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэмд заасны дагуу төвийн даргад тавигдах шаардлага хангасан төвийн даргыг томилж, сонгон шалгаруулалтад оролцох,
4. Нийгмийн даатгалын шимтгэл тогтмол төлсөн, сонгон шалгаруулалтын материал хүлээн авах цаг хугацаанд шимтгэлийн өргүй байх,
5. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авч үнэлгээ хийгдэж эхлэх өдрийн байдлаар татварын өргүй байх,
6. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах цаг хугацаанд шүүхийн шийдвэрээр албадан хэрэгжүүлэх арга хэмжээгүй байх,
7. Сонгон шалгаруулалтад оролцох баг нь ямар нэг үйл ажиллагаа давхар эрхэлдэггүй байх, эсвэл эрхэлж байсан бол зээл, өр авлагагүйг илэрхийлэх баримт, нотолгоог хавсаргасан байх,
8. Баг нь Өрхийн эрүүл мэндийн төвийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй байх. Төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгасан байх. Үүнд:
 - i. Стратегийн зорилго, зорилтыг тодорхойлсон байх;
 - ii. Байгууллагын эрхэм зорилго, хүн амын хамрах хүрээ, үйлчлэх хүн амын эрүүл мэндийн байдалд үнэлгээ, дүгнэлт өгч, үйл ажиллагааны зорилтот түвшин, түүнд хүрэх үйл явц, цогц арга хэмжээг тодорхойлсон байх;
 - iii. Байгууллагын үйл ажиллагааг мэдээллийн технологи, маркетинг, санхүүгийн удирдлагад суурилан удирдан явуулахаар төлөвлөсөн байх;
 - iv. Төвийн хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байх;
 - v. Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг батлагдсан журмын дагуу боловсруулж, магадлан итгэмжлэлд хамрагдах асуудлыг тусгасан байх;
 - vi. Аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороотой хамтран ажиллах төлөвлөгөөтэй байх;

Хоёр. Тавигдах тусгай шаардлага

Нөхөрлөлийн гишүүд нь Оюут багийн бүртгэлтэй 9581 оршин суугчид тохируулан 5 их эмч, 7 сувилагч, 1 эрүүл мэндийн нийгмийн ажилтан, 1 дүн бүртгэлийн ажилтан, гэрээгээр ажиллах боломжтой 3 ба түүнээс дээш бусад ажилтнаас бүрдэнэ.

Хүснэгт 1. Хүний нөөцөд тавигдах шаардлага

№	Албан тушаал	Мэргэжил	Шаардагдах хүний нөөцийн тоо хэмжээ	Тавигдах шаардлага
1	Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга	Хүний их эмч	1	<ul style="list-style-type: none">• Мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш ажилласан• Нөхөрлөлийн гишүүн байх• Хамт олны саналаар сонгогдсон байх

				<ul style="list-style-type: none"> • Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй зөвшөөрлийн гэрчилгээтэй байх
2	Өрхийн эмч	Хүний их эмч, Өрхийн анагаах ухаан болон ерөнхий мэргэжлийн эмч	4 ба түүнээс дээш	<ul style="list-style-type: none"> • Нөхөрлөлийн гишүүн байх. • Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй зөвшөөрлийн гэрчилгээтэй байх. • Өрхийн эмчийн 50%-ийг өрхийн анагаах ухаан, ерөнхий мэргэжлийн эмч, уламжлалт анагаах ухаан, хүүхэд судлал, дотор судлал, эх барих, сэргээн засах, эмэгтэйчүүд судлалын чиглэлээр мэргэшсэн эмчээр бүрдүүлж болно.
3	Өрхийн сувилагч	Сувилагч	4 ба түүнээс дээш	<ul style="list-style-type: none"> • Нөхөрлөлийн гишүүн байх. • Сувилах үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй зөвшөөрлийн гэрчилгээтэй байх.
4	Өдрийн эмчилгээний сувилагч	Сувилагч	1	<ul style="list-style-type: none"> • Нөхөрлөлийн гишүүн байх. • Сувилах үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй зөвшөөрлийн гэрчилгээтэй байх.
5	Дархлаажуулалтын сувилагч	Сувилагч	1	<ul style="list-style-type: none"> • Нөхөрлөлийн гишүүн байх. • Эмнэлгийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй зөвшөөрлийн гэрчилгээтэй байх.
6	Сэргээн засах, уламжлалтын сувилагч	Сувилагч	1	<ul style="list-style-type: none"> • Нөхөрлөлийн гишүүн байх. • Эмнэлгийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй зөвшөөрлийн гэрчилгээтэй байх.
7	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан	Нийгмийн эрүүл мэнд	1	Нөхөрлөлийн гишүүн байх.
8	Дүн бүртгэлийн ажилтан	Бусад мэргэжил	1	Нөхөрлөлийн гишүүн байх.
9	Бусад ажилтан	Шүдний эмч, хөдөлгөөн засалч, сэтгэл судлаач, нягтлан бодогч, жолооч, үйлчлэгч	3 ба түүнээс дээш	Гэрээгээр ажиллах эсвэл үндсэн ажилтан байх.

Гурав. Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт

1. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт бүхий албан тоот,

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар,
3. Байгууллагын батлагдсан дүрэм эх хувиар,
4. Нөхөрлөлийн гишүүдийн үүсгэн байгуулагдсан мөн уг сонгон шалгаруулалтад оролцох, түүнийг дэмжсэн агуулга бүхий нөхөрлөлийн хурлын тэмдэглэлүүдийг эх хувиар,
5. Сонгон шалгаруулалтад оролцох нөхөрлөл болон багийн бүх гишүүдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт,
6. Сонгон шалгаруулалтад оролцох нөхөрлөл нь татвар, нийгмийн даатгалын газрын өр, төлбөргүй эсэх тодорхойлолт,
7. Сонгон шалгаруулалтад оролцох багийн гишүүд нь банкны хугацаа хэтэрсэн зээл, өргүй байх ба зээлийн мэдээллийн нэгдсэн сангаас авсан лавлагаа,
8. Өрхийн эрүүл мэндийн төвийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө,
9. Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөө /Эрүүл мэндийн сайдын 2024 оны 112 дугаар тушаалын 3-р хавсралтаар батлагдсан загварын дагуу боловсруулж, ЭМГ-ын холбогдох мэргэжилтнээр хянуулж, нөхөрлөлийн дарга баталгаажуулсан байх/,
10. Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нь хамт олны олонхын саналаар сонгогдсон байх тул шийдвэр, нотлох баримт,
11. Өрхийн эрүүл мэндийн төвийн даргыг мэргэжлээрээ ажилласныг нотлох Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг E-Mongolia-аас сонгон шалгаруулалт зарласан өдрийн дараах байдлаар,
12. Бүх ажилтнууд сургууль төгссөн дипломын хуулбар эсвэл E-Mongolia-аас авсан боловсролын лавлагааг ирүүлэх,
13. Бүх эмнэлгийн мэргэжилтнүүд эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх,
14. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, мэргэжлийн үүргийг чанд биелүүлж, хамт олон баг бүрдүүлж ажиллахыг тодорхойлсон байх /Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг чанд сахин биелүүлэх тухай мэдэгдэл ирүүлэх/

Дөрөв. Сонгон шалгаруулалтын баримт бичиг хүлээн авах.

Хугацаа: Сонгон шалгаруулалтад оролцох нөхөрлөлийн баримт бичгийг 2026 оны 04 дугаар сарын 22-ний өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 13-ний 17 цаг хүртэл цаасаар болон цахимаар нэг PDF файл болгон khongorzul_a@or.moh.gov.mn хаягаар ажлын өдрүүдэд 08-17 цаг хүртэл ирүүлнэ.

Хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Төрийн захиргааны 4-р байр, 206 тоот

Хүлээн авагчийн нэр: Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн А.Хонгорзул

Утасны дугаар: 70350659, 95850851

Анхаарах зүйлс:

1. Баримт бичгийг дугтуйнд битүүмжилсэн байх ба “Оюут багийн шинэ өрхийн эрүүл мэндийн төвийн багийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороонд” гэж хаяглан, сонгон шалгаруулалтад оролцогч иргэний нэр, холбоо барих утасны дугаарыг гаргацтай бичнэ;
2. Баримт бичгийг нөхөрлөлийн дарга эсвэл гишүүн нь биеэр авчирч өгөх ба цахим болон цаасаар материал зэрэг ирсэн тохиолдолд тулгалт хийж, материал хүлээн авсан гэх бүртгэл хөтлөгдсөнөөр материалыг хүлээн авсанд тооцно;
3. Нэг дугтуйнд зөвхөн 1 сонгон шалгаруулалтын баримт бичгийг хийнэ;
4. Баримт бичгийг сонгон шалгаруулалтын дараа буцаан олгохгүй;
5. Хугацаа хоцорсон баримт бичгийг хүлээн авахаас татгалзана;

